

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу хийсэн.

Нэг. Хуулийн этгээдийн зардал

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээдэд заавал биелүүлэх шинжтэй үүрэг хариуцлага тусгаагүй тул нэмэгдэл зардал үүсэхгүй.

Хоёр. Төрийн байгууллагын зардал буюу орон нутгийн төсөвт үүсэх зардал

Шинжлэх ухааны болон оюуны нөөц, чадавхиа нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагаа бэхжүүлэхийн тулд хос санхүүжилтийн механизмтай байх нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд төсвийн нэмэлт санхүүжилт шаардагдахгүй. Улсын төсвөөс зарцуулж байгаа эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтэд хуваарилалт хийх буюу суурь судалгааны төсөлд жил бүр зарцуулж буй зардлын зарим хэсгийг энэхүү зардалд шилжүүлэх замаар шийдвэрлэх бүрэн боломжтой гэж тооцоолсон.

Хуулийн төслийн 16.6 дахь хэсэг нь Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагуудыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцөл боломжоор хангах, санхүүгийн бие даасан байдлыг хууль эрх зүйн хувьд баталгаажуулах зорилготой. Одоогийн байдлаар Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолоор байгуулагдсан 24 хүрээлэнгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Уг тогтоолд 6 хүрээлэнг их сургуулиудын бүтцэд багтаан төсвийн бус санхүүжилттэй байхаар зохицуулсан. Улсын төсөв боломжтой болсон нөхцөлд эдгээр хүрээлэнгүүдийн урсгал зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлэх шаардлага байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд төрийн байгууллагатай холбоотой нэмэгдэл зардал гарахгүй гэж үзэж байгаа бөгөөд одоогийн хүний нөөц, төсвийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой.

Гурав. Иргэний зардлыг тооцох

Уг хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэдэд үүсэх, нэмэгдэх зардал байхгүй.

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН
НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЪЁОГ**

№	ЦАХИМ ХУУДСАНД ТАВИГДСАН ТӨСӨЛ	ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ	АКАДЕМИЙН ГИШҮҮДИЙН ГАРГАСАН САНАЛ	ТАЙЛБАР
1.	“3.1.9. “судалгаа боловсруулалтын ажил” гэж шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
2.	“3.1.10.“суурь санхүүжилт” гэж байгууллагын судалгаа боловсруулалтын ажлын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан эрдэм шинжилгээний байгууллагад улсын төсвөөс олгох хөрөнгийг;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
3.	“8.1.16. эрдэм шинжилгээний ажилтныг магадлан итгэмжлэх журам батлах;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
4.	“8.1.17. шинжлэх ухаан, технологийн төсөлд тавигдах шаардлага, шинжээч ажиллуулах, үнэлгээ өгөх аргачлалыг батлах;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
5.	“8.1.18. археологи, палеонтологийн хайгуул малтлага явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд хяналт тавих, авран хамгаалах үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлт хийх журмыг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй

6.	“8.1.19. шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
7.	“8.1.20. салбар дундын ашиглалтай үндэсний хэмжээний болон нээлттэй лабораторийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг батлах;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
8.	“11.15. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
9.	“13.1.10. эрдэм шинжилгээний байгууллага нь үндсэн чиг үүргийн дагуух үйл ажиллагаанаас олсон орлогыг арилжааны банкны дансанд төвлөрүүлж захиран зарцуулах;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
10.	“16 ¹ дүгээр зүйл.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
11.	16 ¹ .1. Энэ хуулийн 15.1.1-д заасан хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгаа боловсруулалтын ажлын тайланг гүйцэтгэгч нь дараах материалын хамт итгэмжлэгдсэн хадгалагчид хүлээлгэн өгнө.”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
12.	16 ¹ .1.1. энэ хуулийн 11.3-д заасан эрдмийн зөвлөлийн болон шинжлэх ухааны академийн бага чуулганы шийдвэр;	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй

13.	16 ¹ .1.2. яамдын захиалгаар гүйцэтгэсэн бол тухайн яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн шийдвэр;	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
14.	16 ¹ .2. Энэ зүйлийн 1-д заасан тайланг бичих, хэлэлцүүлэх, хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулах журмыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
15.	“19.2.3. эрдэм шинжилгээний ажилтан”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
16.	“19.5. Энэ зүйлийн 19.4-д заасан магадлан итгэмжлэлд хүндэтгэн үзэх шалтгаанаар хамрагдаагүй эрдэм шинжилгээний ажилтныг магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жилд 1 удаа зохион байгуулж болно.”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
17.	“3.1.2. “шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа” гэж эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх цогц үйл ажиллагааг;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
18.	“3.1.6. “грант” гэж урьдчилсан нөхцөл, болзлын дагуу судалгаа боловсруулалтын зориулалтаар буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
19.	“5.1.5.эрдэм шинжилгээний байгууллага;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
20.	“8.1.3.Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх судалгаа	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй

	боловсруулалтын ажлын санхүүжилтийн хуваарийг тогтоох, шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах, хэрэгжилтийг хангах;"			
21.	"11.3.Эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн эрхэлсэн салбарын эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулан судалгаа боловсруулалтын ажлын чиглэл, явц, үр дүнг хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна."	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
22.	"11.12.Энэ хуулийн 11.2.4-т заасан байгууллага нь судалгаа боловсруулалтын ажлыг дангаараа, эсхүл эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд түүнийг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно."	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
23.	"16.1. Энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх судалгаа боловсруулалтын ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу хянан магадлагаа хийж шалгаруулна."	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
24.	"16.2. Энэ хуулийн 16.1-д зааснаар шалгарсан судалгаа боловсруулалтын ажлыг санхүүжүүлэхэд олгох хөрөнгийн хэмжээг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно."	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй

25.	“17.1.1. шинжлэх ухаан, технологийн төслөөр шийдвэрлүүлэх асуудлыг тодорхойлон шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
26.	“17.2.6.Шинжлэх ухаан, технологийн төслийг сантай хамтарсан санхүүжүүлэх бол уг төсөлд оруулах өөрийн хөрөнгийг Санд байршуулж зарцуулах.”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
27.	“19.1.Эрдэм шинжилгээний ажилтан нь судалгаа боловсруулалтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажиллах эрхтэй.”	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
28.	“21.1.3.энэ хуулийн 11.2-т заасан байгууллагад 25 ба түүнээс дээш жил судалгаа боловсруулалтын ажил эрхэлсэн эрдэм шинжилгээний болон инженер-техникийн ажилтан, лаборант-т өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол ажиллаж байгаа байгууллагаас нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох;	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй
29.	22.1.1.судалгаа боловсруулалтын ажил эрхэлж байгаль, нийгмийн шинэ үзэгдэл, хуулийг тодорхойлж, шилдэг бүтээл туурвисан иргэн, судлаачдын хамтлаг “байгаль, нийгмийн ухааны шагнал”;	Үгүй	Саналыг дэмжсэн.	байхгүй